

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 3 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Засаг даргын тамгын газрын хамт олон тухайн сард 2 удаа хуралдаж ажилтан албан хаагчдын тайлан онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, хөдөлмөрийн гэрээний шинэчлэл, дотоодод зохион байгуулах сургалтын төлөвлөгөө, бусад өдөр туьмын ажлын талаар хэлэлцлээ. Тогтвортой хөгжил Алсын хараа-2050 цахим сургалтанд албан хаагчид бүрэн хамрагдаж сертификат хэвлэн авсан

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр

Том малын зүй бус хорогдлын мэдээг гаргасан ба сумын хэмжээнд 431 том малын зүй бус хорогдол гарсан байна. Төл малын хорогдлын мэдээг гаргаж байгаа ба эцсийн тоо гараагүй байна.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

“Халдварын сэргийлэлт хяналт-2023” арга хэмжээг ЭМГазартай хамтран зохион байгуулж 6 сумын нийт 32 албан хаагч оролцсон.

Март 8-наар ахмад ажилчдад хүндэтгэл үзүүлж нийт 17 ахмадад гарын бэлэг өгсөн. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах баярын өдрөөр ахмад ажилтан А.Сарантуяа алтан гадас одонгоор шагнагдсан.

Монгол цэргийн баярын өдрийг угтан ЗДТГазартай хамтран урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг зохион байгуулсан ба баярын өдрөөр зохион байгуулсан караоке тэмцээнд ЭМТөвийн баг 1-р байр эзэлсэн.

ЭМТөвд төрсөн эх – 0
Нийт төрсөн эх – 15
Нас баралт – 7 / хавдар-3, бусад-4/
Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч – 128
Ор хоног – 873
Нийт үзлэг – 1241
Эрэгтэй – 536
Эмэгтэй – 705
Урьдчилан сэргийлэх үзлэг –247
Идэвхитэй хяналт – 404
Жирэмсний хяналт-15/13/86,6%
Амбулаторийн үзлэг – 457
 Анхан – 202
 Давтан – 248
Гэрийн дуудлага – 121
Халдварт өвчлөл – 0
 Шинэ-0
 Хуучин -0
Түргэн тусламжийн дуудлага – 197

Алсын дуудлага – 76
Осол гэмтлийн дуудлага – 8
Эрт илрүүлэг үзлэг
Хөхний өмөн – 870/80/9,2 %
Умайн хүзүүний өмөн – 220/12/6%
Артерийн даралт ихдэлт – 970/37/4%
Чихрийн шижин – 1400/161/11,5%
Сургалт сурталчилгаа
Тараах материал-4
Цахим хуудас-50 төрлийн мэдээлэл байршуулж 10100 хүний хандалт
Танхимын сургалт -3 удаа 86 хүн хамруулсан

Итали улсын хөрөнгө оруулалттай Asia mongolia ТББ-аас хэрэгжүүлж буй "Орон нутгаас Дэлхий рүү" төслийн хүрээнд МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ХЭРЭГЛЭЭ, КОД БИЧИХ ӨДӨРЛӨГИЙГ зохион байгууллаа.

1. Ухаалаг самбар ашиглан хичээл заасан багш нарын болон хичээлд суусан сурагчдын сэтгэгдлээр үзэсгэлэн гаргаж мэдээлэл технологийн хэрэглээ болон ухаалаг самбарын ач холбогдлыг танилцууллаа.

2. Багш нарт зохион байгуулсан сургалт, багш нарын ухаалаг самбар ашиглан хичээл заасан ур чадварын уралдаан, мөн цэцэрлэгийн багш нарт зориулан заасан үзүүлэх хичээл зэрэг үйл ажиллагааны зургаар тайлан гаргалаа.

3. Код бичих дугуйлангийн сурагчдад дугуйланг хичээллээ.

Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргаанаас "Дэлхийн усны өдөр"-т зориулан 7-9 дүгээр ангийн сурагчдад уг өдрийн талаар мэдээлэл хийж, "Үсэглэлийн аварга" тэмцээнийг зохион байгууллаа.

Тэмцээнд 40 гаруй суралцагч оролцлоо.

ДЭЛХИЙН МӨНГӨНИЙ ДОЛОО ХОНОГ - 2023 аяны хүрээнд Монгол банкны салбар, Насан туршийн боловсролын төвтэй хамтран 8-9 ангийн нийт 67 сурагчдад "Хуримтлал, Халаасны мөнгөө зарцуулах төлөвлөгөө сэдвээр сургалт зохион байгууллаа.

Аймагт зохион байгуулагдсан "Улсын төрөлжсөн олимпиадын II даваа"-нд "Орос хэл"-ний хичээлийн төрөлд орос хэлний багш Г.Сумъяа III байр эзэлж "Хүрэл" медаль, авлаа.

Аймагт зохион байгуулагдсан "Улсын төрөлжсөн олимпиадын II даваа"-нд "бага ангийн-МАТЕМАТИК"-ийн төрөлд бага боловсролын багш Г.Мөнхцэцэг III байр эзэлж "Хүрэл" медаль, Орос хэл"-ний хичээлийн төрөлд орос хэлний багш Г.Сумъяа III байр эзэлж "Хүрэл" медаль, авч шагнагдлаа.

Мөн 9а ангийн сурагч Тулга овогтой Мөнхзаяа, манай сургуулийн төгсөгч 10-р ангийн сурагч Ганжуурдалайн овогтой Үүрийнтуяа нар Таеквондогийн "УЛСЫН АВАРГА" болсон амжилттай ажиллаж байна.

Тогтвортой хөгжил Алсын хараа-2050 цахим сургалтанд эрхлэгч, аргазүйч, дуу хөгжмийн багш, бүлгийн багш, туслах багш. Нийт-16 хүн хамрагдаж сертификат гардан авлаа.

Төрийн соёхолт хүүхдийн зохиолч Жамбын Дашдондог асгны нэрэмжит Уран жиргээ-2023 наадамд цэцэрлэгийн 6-н бүлгийн 23 хүүхэд 1-р шатанд оролцож 1-3 байрыг эзлүүлж 1-р байр эзэлсэн нэг хүүхэд аймгийн 2-р шатанд амжилттай оролцсон.

Тогтвортой хөгжлийн зорилт: 6.14 хүрээнд "Дэлхийн усны өдрийг тохиолдуулан 6-н бүлгийн дунд "Ус чандмань эрдэнэ" сэдвээр дамжуулан нээлттэй сургалт үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа

Олон улсын Эко-сургууль, цэцэрлэг хөтөлбөрийн Ахисан шатны 2 дахь сургалт 2023 оны 03 дугаар сарын 23-24-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдаж байна.

СОЁЛ УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Соёлын төв 3 дугаар сард:

- Ирсэн бичиг – 7
- Явсан бичиг – 1
 - Хариутай бичиг – 1
 - Хугацаандаа явсан бичиг – 1
 - Хугацаа болоогүй бичиг – 0
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

1.1. Монгол Улсын Соёлын яамнаас Жишиг соёлын төвүүдийн дунд цахим хурлыг зохион байгуулсан. Тус хуралд Зүүн бүсийн жишиг соёлын төвийн 5 албан хаагч хамрагдсан бөгөөд Соёлын төв, Орон нутаг судлах музейн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудал болон, хүний нөөцийг чадавхижуулах талаар санал солилцож, судалгааг албан байдлаар Соёлын яаманд хүргүүлсэн. Соёлын яам Жишиг Соёлын төвүүдийг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, Сайдад танилцуулахтай холбогдуулан тус судалгаанд бүжгийн багш, техникч, номын санч, соёлын өвийн ажилтан зэрэг албан хаагчдыг чадавхижуулах, Жишиг соёлын төвүүдийн орон тоог нэмэх, Д.Сүхбаатарын Орон нутаг судлах музейн үзмэрийн шинэчлэл сэргээн засварлалтай холбогдох ажлуудыг тусгасан болно.

1.2. Улс, аймаг, сумын аварга малчдын шагнал гардуулах үйл ажиллагаанд Соёлын төвийн дарга Д.Болорцэцэг, дуу хөгжмийн багш Л.Батжаргал нар оролцож, 10 гаруй аварга малчны хот айлд Соёл урлагийн үйлчилгээ үзүүлсэн.

1.3. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, иргэдийн авьяас чадварыг нээн илрүүлэх зорилгоор уламжлал болсон “ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН КАРАОКЕ” дууны тэмцээнийг мэргэжлийн шүүгчээр шүүлгэн, 4 үе шаттайгаар амжилттай зохион байгууллаа. Тэмцээнд хөдөөгийн 4 баг, төрийн албаны 35 эмэгтэй хамрагдсан бөгөөд танхимаар 200 хүнд хүрсэн. Тэргүүн байранд Ланз баг, дэд байранд ЕБС-ийн баг, гутгаар байранд ахмадын баг тус тус шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан. Тэмцээний үйл ажиллагаанд нийтдээ 600.000 төгрөгийг зарцуулсан болно.

1.4. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан “БАЯРЫН ХУРАЛ”-ыг Сумын “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-тэй хамтран танхимаар зохион байгуулсан. Баярын хурлын дараа дугуйлангийн сурагчид, ардын авьяастнууд, цахилгаан хөгжмийн “Дурсамж” хамтлаг оролцсон “Ээжээ дуулъя” хүндэтгэлийн тоглолтыг амжилттай зохион байгууллаа. Тус тоглолтонд 23 уран бүтээлч хамрагдсан бөгөөд танхимаар 250 хүнд хүрсэн.

1.5. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулж, 3-р сарын 7, 8-ны өдрүүдэд хөтөлбөртэй “ҮДШИЙН ЦЭНГҮҮН”-ийг 2 удаа зохион байгууллаа. Хоёр өдрийн цэнгүүнд нийтдээ 338 хүн хамрагдсан болно.

1.6. МУСТА дуучин В.Баттулга, Б.Дуулим нарын “ААВ НЬ ОХИНДОО” уран бүтээлийн аялан тоглолтыг амжилттай зохион байгууллаа. Тоглолыг 300 хүн үзэж сонирхсон. Хамрагсад 3.

1.7. “ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТЭЙ ХЯНАЛТ-2023” Сүхбаатар аймгийн хэмжээний Бүсийн сургалтыг Сумын эрүүл мэндийн төвтэй хамтран зохион байгууллаа. Тус сургалт зөвлөгөөнд эрүүл мэндийн салбарын 32 албан хаагчид хамрагдсан.

1.8. Сүхбаатар аймгийн “ЖУДО БӨХИЙН ӨСВӨР ҮЕИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ” тэмцээн Улсын Тэргүүний Сүхбаатар суманд 2023.03.12-13-ны өдрүүд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээний нээлтийг үйл ажиллагааг Соёлын төвийн хамт олон зохион байгуулж, урлагийн номер бэлтгэн танхимын үзэгчдэд хүргэсэн болно. Нийтдээ 800 гаруй хүн үзэж сонирхсон. Хамрагсад 5.

1.9. МУСТА Дуучин Батсүхийн Отгончимэгийн "ЦОГЛОГ БАЙГААРАЙ" Аялан тоглолтыг 2023.03.12-ны өдөр зохион байгууллаа. Тоглолтонд урилгаар МУСТА Н.Баасандорж, МУСТА Б.Мөнхбат, Уртын дуучин М.Цэрэнпагма нар оролцож, 120 үзэгч үзэж сонирхсон болно.

1.10. Монгол Улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх, уралдаан тэмцээнээр дамжуулан иргэдийн авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор "ЭРЧҮҮД ДУУЛЖ БАЙНА" тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Тус тэмцээнд 4 багийн 20 эрэгтэй дуучин оролцож дуулах ур чадвараар өрсөлдсөнөөс тэргүүн байранд Эрүүл мэндийн төвийн баг, дэд байранд Улсын тэргүүний цэцэрлэгийн баг, гутгаар байранд Баянгол багууд тус тус шалгарч өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Тэмцээний зардалд нийтдээ 641.500 төгрөгийг зарцуулсан болно. Танхимаар 180 хүнд хүрсэн.

1.11. МУСТА элэглэгч дуучин Тоотын ГАНБҮРГЭДИЙН хошин элэглэлийн PARODY амьд шоу тоглолтыг 2023.03.15-ны өдөр зохион байгуулсан. Тус тоглолтыг танхимаар 160 хүн үзэж сонирхсон. Хамрагсад 4.

1.12. Сүхбаатар аймгийн Ахмадын хорооноос зарласан "ЕРӨӨЛИЙН БУЯНТАЙ БУУРЛУУД" найрал дууны уралдаанд Улсын Тэргүүний Сүхбаатар сумын ахмадуудыг хамруулсан бөгөөд бичлэг болгон олон нийтийн сүлжээнд байршуулсан. Тус дууны уралдаанд 21 ахмадыг хамруулж, цахим орчинд 4000 хүнд хүргэсэн.

ХОЁР: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Улсын тэргүүний номын сангаас Монгол улсад орчин цагийн зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 102 жилийн ой, Монгол цэргийн өдөрт зориулан аавуудыг алдаршуулах, ааваараа бахархах, дурсамжаа хуваалцах, хэлэхийг хүсдэг болон хэлж амжаагүй сэтгэлийн үгээ захидал болон шүлгээр дамжуулан илэрхийлэх зорилгоор зохион байгуулсан "МИНИЙ БААТАР-ТЭНГЭРЛЭГ ААВДАА" уралдааныг 3 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.

Уралдааны насанд хүрэгчдийн төрөлд Этүгэн их сургуулийн 4-р дамжааны оюутан Г.Бямбажав тэргүүн байр, ЕБС-ийн бичиг хэргийн ажилтан Г.Дуламханд дэд байр, иргэн Д.Дэлгэртуяа гутгаар байрыг тус тус эзлэсэн бол Хүүхдийн төрөлд Сүхбаатар аймгийн 3-р сургуулийн 11-р ангийн сурагч Б.Хишигжаргал тэргүүн байр, ЕБС-ийн 7а ангийн сурагч Э.Сарангарав дэд байр, ЕБС-ийн 7а ангийн сурагч Г.Үржинханд гутгаар байруудад тус тус шалгарч, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаж урамшууллаа. Уралдааны төсөвт нийтдээ 256.500 төгрөгийг зарцуулсан болно. Шалгарсан захидлуудыг цахимд байршуулж, 712 хүнд хүргэсэн.

Бүүвэйн дуунд уяран өссөн хүн бүхэн ЭХ хүний ач буяныг дээдлэн хайрлах, эх үрийн нандин холбоог чин сэтгэлийн нандин үгээр илэрхийлсэн захидлаар ээждээ сэтгэлийн бэлэг барих, захидлаар дамжуулан бичгийн соёл эх хэлний найруулага зүй, бичих ур чадварыг сайжруулах зорилгоор "ЭЭЖДЭЭ ЗАХИДАЛ БИЧЭЭРЭЙ" уралдааныг 12 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Уралдааны насанд хүрэгчдийн төрөлд Москвагийн хуулийн их сургуулийн оюутан М.Бямбажав тэргүүн байр, 3-р багийн иргэн Г.Ариунзул дэд байр, ЗДТГ-ын мэргэжилтэн Э.Дэлхийцэцэг гутгаар байрыг тус тус хүртсэн бол хүүхдийн төрөлд Сүхбаатар аймгийн 3-р бүрэн дунд сургуулийн 12-р ангийн сурагч С.Болор-Эрдэнэ тэргүүн байр, Сүхбаатар аймгийн 2-р бүрэн дунд сургуулдийн 10-р ангийн сурагч А.Оюун-эрдэнэ дэд байр, Сүхбаатар сумын ЕБС-ийн 5а ангийн сурагч Б.Баттулга гутгаар байруудын тус тус эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Тус уралдааныг 2-р багийн хувиараа хөдөлмөр эрхлэгч Г.Болдбаатарын гэр бүлээс жил бүр ивээн тэтгэдэг бөгөөд энэ жилийн захидлын уралдааны төсөвт 670.000 төгрөгийг зарцуулсан. Шалгарсан захидлуудыг цахимд байршуулж 777 хүнд хүргэсэн.

Монгол Улсын УИХ-ын гишүүн Н.Ганибалын ивээн тэтгэлэгээр зохион байгуулагддаг шилдэг уншигч шалгаруулах "СУДАР ЭГШИГЛЭН-2023" уралдаанд Сүхбаатар сумаас 10 гаруй уншигч оролцож байна.

ГУРАВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сүхбаатар сумын Мөнхэрдэнэномунхан хийдийн "Их Цогчин" дуганы цогцолборын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, иргэд сүсэгтэн олонд зориулж Сүхбаатар аймгийн "Жаахан шарга" театрын уран бүтээлчид, дугуйлангийн сурагчид, ардын

авьяастнуудыг хамруулсан урлагийн тоглолтыг өргөн барьсан. Нийтдээ 10 уран бүтээлчийг хамруулж, 780 хүнд хүрч үйлчилсэн болно.

Мөн хийдийн лам нарт зориулж гар урлалын өвлөн уламжлагчид, багийн 50 эмэгтэйчүүдийг оролцуулан 8 /найман/ эсгий олбого оёулж, Мөнхэрдэнэномунхан хийдэд хандивласан. Энэхүү хийд орон сүндэрлэснээр соёлын өвийг судлан баримтжуулах, түгээн дэлгэрүүлэх өргөн боломж нээгдсэн юм. Цаашилбал улсын хэмжээнд яригдах маш том бүтээн байгуулалтын ажил өрнөсөн болно. Тухайлбал 2 тэр бум төгрөгний өртөгөөр сүндэрлэсэн тус хийд нь 3000 лам хуврагууд шавилан суудаг байсан Сэцэн хан аймгийн хошуу хийд байсан түүхтэй.

Соёлын өвийг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой Сүхбаатар аймгийн ахмадын "ХАВЧААХАЙ ХАРВААНЫ" ээлжит тэмцээн Сүхбаатар сумын Зүүн бүсийн Жишиг Соёлын төвийн байранд 2023.03.11-12-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Сүхбаатарын аймгийн 10 сумын 120 гаруй ахмад харваачид оролцсон болно.

ДӨРӨВ: ДУГУЙЛАНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

4.1. Соёлын төвийн дэргэдэх дуу хөгжмийн дугуйланд 8 хүүхэд тогтмол хамрагдаж байна.

ТАВ: БУСАД ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Бүжгийн багш С.Ганзориг өөрийн хүсэлтээр ажлаасаа чөлөөлөгдөж, бүжгийн багшийн орон тоон дээр нээлттэй сонгон шалгаруулалт зарласан.

Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын Зүүн бүсийн жишиг соёлын төв нь 2023 оны гуравдугаар сарын байдлаар **17** үйл ажиллагаа зохион байгуулж, танхимын болон явуулын үйлчилгээгээр танхимаар болон цахимаар **8,279** үзэгчдэд соёл урлагийн үйлчилгээ, арга хэмжээг хүргэн ажилласан. Хамрагсадын тоо **686**

МЭДЭЭ ГАРГАСАН :

Дотоод ажилтан, Хууль, эрх зүйн мэргэжилтэн

/С.Ариунзаяа/

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/

СҮХБААТАР АЙМГИЙН СҮХБААТАР СУМ ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Засаг даргын зөвлөл 2 удаа хуралдаж тайлант оны Хяналт, шинжилгээний үнэлгээний тайлан мэдээний тайлагналт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон аймгийн сайн малчинд нэр дэвшсэн малчдын материалыг хэлэлцэв.

2023 оны 1 сарын 20-нд төрийн албан хаагчдын анхдугаар урлагийн наадам 5 төрлөөр зохион байгуулагдаж, төсөвт 6 байгууллага, 1 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, 2 банк, Ник шатахуун түгээх газрын ажилтан гээд, 120 орчим ажилтан, албан хаагч хамрагдав.

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын мэдээлэл технологи, сүлжээ хариуцсан Ц.Гэрэлт-Од мэргэжилтний зохион байгуулсан Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем /ERP/-ийн сургалтанд төрийн байгууллагын ажилтан албан хаагчид хамрагдав.

Байгаль орчин , Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Шинэ оны анхны нар харах аялаллыг Дархан хаан ууланд зохион байгуулсан. Тус аялалд 53 морьтон залуус болон 400 гаруй хүн оролцсон байна. Аялалын хүрээнд морьтон залуучуудын дунд ташуур шүүрэх, цасны сумо тэмцээнийг зохион байгуулсан.

Болзошгүй аюул, эрсдлээс зэрлэг амьтдаа хамгаалах, ямарваа нэг хорогдол гаргахгүй байх зорилгоор Байгаль орчны хяналтын улсын байцаагч болон Цайрт минериал ХХК-ны Байгаль орчин Хөдөлмөр аюулгүй ажиллагааны тасгийн хамт олонтой хамтран Дархан хаан ууланд нутагшиж буй Аргаль хонинд биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Анх Дархан хаан ууланд 2009, 2012, 2017 онуудад Аргаль хонь ирж нутагшиж өсөж үржсээр 19 болж нэмэгдээд байгаа билээ. Дархан уулын аргаль хонинд 22 боодол өвс, 700 кг Хужир 5 газарт тараан байршуулж биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүллээ.

Аймгийн сайн малчинд нэр дэвшсэн 3 малчны материалыг аймгийн Хөдөө аж, ахуйн газарт хүргүүлсэн.

Эрүүл мэнд, Боловсролын чиглэлээр:

Ерөнхий боловсролын сургуулийн байгалийн ухааны багш нарыг чадавхжуулах нь 2 өдрийн сургалтанд 5 хамрагдсан

ЭМТөвд төрсөн эх – 0

Нийт төрсөн эх – 10

Нас баралт – 3 /ЗС-1, хавдар-2/

Эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгч – 32

Ор хоног – 219

Нийт үзлэг – 413

Эрэгтэй – 193

Эмэгтэй – 220

Урьдчилан сэргийлэх үзлэг – 99
Идэвхитэй хяналт – 94
Жирэмсний хяналт-54/44/81,4%
Амбулаторийн үзлэг – 191
 Анхан – 90
 Давтан – 101
Гэрийн дуудлага – 21
Халдварт өвчлөл – 0
 Шинэ-0
 Хуучин -0
Түргэн тусламжийн дуудлага – 55
 Алсын дуудлага – 34
 Осол гэмтлийн дуудлага – 0
Эрт илрүүлэг үзлэг
 Хөхний өмөн – 690/330/48 %
 Умайн хүзүүний өмөн – 232/101/56%
 Артерийн даралт ихдэлт – 1970/1220/62%
 Чихрийн шижин – 1250/1209/96,6%
Сургалт сурталчилгаа
Тараах материал-1
Цахим хуудас-28 төрлийн мэдээлэл байршуулж 3100 хүний хандалт
Танхимын сургалт -2 удаа 48 хүн хамруулсан

Соёл урлагийн чиглэлээр:

Соёлын төв 1 дүгээр сард:

- Ирсэн бичиг – 1
- Явсан бичиг – 1
 - Хариутай бичиг – 1
 - Хугацаандаа явсан бичиг – 1
 - Хугацаа болоогүй бичиг – 0
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

НЭГ: ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

Сумынхаа ард иргэдэд соёл урлагийн үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэж, ажилдаа тогтмол амжилт гаргадаг үр дүнгээр Улсын тэргүүний Сүхбаатар сумын 2022 оны “**Шилдэг байгууллага**”-аар Зүүн бүсийн Жишиг Соёлын төв шалгарсан.

Жишиг Соёлын төвүүдийн орчин нөхцөл, үйл ажиллагааг дэмжих бодлогын хүрээнд Монгол улсын Соёлын яамнаас Зүүн бүсийн Жишиг Соёлын төвд 25.534.300 төгрөгний **хөрөнгө оруулалт** хийгдлээ. Үүнд үзэгчийн сандал, оффис ширээ сандал, бичиг хэргийн шүүгээ, хурлын ширээ сандал, хурлын индэр зэрэг багтсан болно.

Соёл урлагийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй хүргэх үүднээс Монгол цахилгаан холбооны Сүхбаатар аймгийн салбартай хамтран Соёлын төвийн байранд шилэн кабелийн сүлжээ нэвтрүүлсэн. Шилэн кабелийн төлбөр болох 2.000.000 төгрөгийг Соёлын яамны санхүүжилтээр шийдсэн бөгөөд кабель суурилуулснаар цахим орчинд ажиллах боломж нөхцөл бүрдэж, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хангасан.

ХОЁР: НОМЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралтай хамтран Монгол Улсын Үндсэн Хуулийн өдөрт зориулан **"Үндсэн хуулийн мэдлэг"** дугуй ширээний ярилцлагыг амжилттай зохион байгууллаа. Ярилцлаганд хуульч, төрийн байгууллагын төлөөлөл, хувийн хэвшлийн төлөөлөл, иргэдийн төлөөлөл оролцож, Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэг "Хүний эрх, эрх чөлөө" талаарх мэдлэг, мэдээлэл, солилцсон, шинэ санаа дэвшүүлэн, иргэдэд хуулийн мэдлэгийг дээшлүүлэхэд бодит нөлөөлөл үзүүлэж ажиллаа. Танхимаар **15** хүнийг хамруулсан.

ГУРАВ: СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол адууны өв соёлыг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Улсын Тэргүүний Сүхбаатар сумын ЗДТГ, Биеийн тамирын арга зүйч Ц.Ган-Өлзий, 1-р багийн засаг дарга Б.Баттулга, "Адуучдын холбоо"-той хамтран "Түмэн адууны баяр"-т зориулсан Сумын аварга адуучин шалгаруулах **"Адуучин"** тэмцээнийг амжилттай зохион байгуулсан. Тэмцээнд нийт 67 адуучин залуус оролцсон бөгөөд шагналын санг малчид, уяачидаас хандив бүрдүүлэн ажиллаа. Нийт 5-н шагналт байрыг шалгаруулсан болно. Нүүдлийн үйлчилгээгээр **170** хүнд хүрч **67** хүнийг хамруулсан.

МЭДЭЭ ГАРГАСАН :

Хууль, эрх зүйн мэргэжилтнийг түр орлон гүйцэтгэгч:

Э.Дэлхийцэцэг

ХЯНАСАН:

Засаг даргын Тамгын газрын дарга

/Ц.Сүхболд/